



**ДОРНОД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

21000, Дорнод аймаг, Хэрлэн сум 7-р баг  
ЗДТГ-ын II байр, Утас/Факс: 7058-4203

Г ДОРНОД АЙМГИЙН ИРГЭДИЙН  
төлөөлөгчдийн хурлын сонгуульд оролцох  
дорнод аймгийн ардчилсан намын  
дарга удаш танаа

2020.08.13 № 518

таний \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

Г Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орон нутгийн Хурлын сонгуульд оролцох Дорнод аймгийн ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох нам нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль болон “Алсын хараа-2050”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцох намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аudit MNS 6817 - 1 : 2020 Тулгуур зарчим, Төрийн аudit MNS 6817 - 6 : 2020 Нийцлийн аудитын зарчим, Төрийн аudit MNS 6817 - 8 : 2020 Нийцлийн аudit стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон “Алсын хараа-2050”, холбогдох бусад байгууллагаас авсан мэдээллийг шалгуур болгосон.

**Дүгнэлт**

“Дорнод аймгийн ардчилсан нам”-ын аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуульд оролцоо ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, “Алсын хараа-2050”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Дорнод аймгийн ардчилсан нам”-ын мөрийн хөтөлбөр 10 хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Дорнод аймгийн сонгуулийн хороонд

Хавсралт 10 хуудастай.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ



011020605



Дорнод аймгийн Ардчилсан нам

2020 оны Орон нутгийн сонгуулийн мөрийн хөтөлбөр

## 2020 оны Орон нутгийн сонгуульд оролцох Дорнод аймгийн Ардчилсан Намын мөрийн хөтөлбөр

Монгол улсын тусгаар тогтнол, Үндэсний эрх ашиг, Үндсэн хуулт ардчилалаа хамгаалан бэхжүүлж, хувь хүний эрх чөлөө, хуулийн засаглал, чөлөөт зах зээл, иргэний нийгмийн зарчимд суурилсан тогтвортой хөгжлийн төлөөх баруун төвийн намын хувьд

Монгол хүн бүр хүсэл мөрөөдөлтэй, өрх бүр аз жаргалтай амьдрах хөгжлийн боломжийг дэмжсэн, иргэд нь эрх чөлөөтэй, эрх тэгш, хариуцлагатай байж, ДОРНОД нутгаа хөгжүүлэхийг ЭРХЭМ ЗОРИЛГО болгож,

| Дорнод аймгийн нийгмийн суурь тулгамдсан асуудлыг бодитоор шийдвэрлэж иргэдийнхээ эрх, эрх чөлөө, бие даасан байдлыг хангах,

| Бүс нутгийн хөгжлийн интеграцид санаачлагатай оролцож, хувийн өмч, өрсөлдөөнт зах зээл, төрийн хязгаарлагдмал оролцоо, хуулийн засаглалын үндэс суурийг бэхжүүлэх,

| Үндэсний өв уламжлал, түүх соёлоо дээдлэн, Ардчиллын үнэт зүйлийг сахин хамгаалахыг зорилгоо болгон тунхагласан

Дорнод аймгийн Ардчилсан нам 2020-2024 оны Орон нутгийн сонгуульд оролцож өрх гэрүүдийн амьдралын чанарыг бодитоор дээшлүүлэх үзэл санаанд тулгуурласан “Шинэ Дорнод” мөрийн хөтөлбөрөө Та бүхэндээ толилуулж байна.

### Нэг.Хүн төвтэй, шинэ ДОРНОД

- Өрсөлдөх чадвартай боловсрол
- Чанартай Эрүүл мэндийн үйлчилгээ
- Нийгмийн хамгаалал
- Соёл,урлаг,спорт
- Хүрээлэн буй орчин, ногоон хөгжил
- Иргэний хамгаалал

### Хоёр.Баялаг бүтээгч, шинэ ДОРНОД

- Хямралын бодлого
- Эдийн засгийн өсөлтийн бодлого
  - Үйлдвэржилт
  - Бизнес эрхлэлт
  - Дэд бүтэц
  - Шинжилэх ухаан, технологи, инновац
  - Хөдөө аж ахуй, газар тариалан

### Гурав.Эзэнтэй, шинэ ДОРНОД

- Аймаг, сумын хөгжлийн тэнцвэр
- Шинэ засаглал
  - Нээлттэй, иргэний хяналт

- Хариуцлагатай, чадварлаг
- Баялагтаа эзэн

Дөрөв.Алсаа харсан, шинэ ДОРНОД

- Гадаад хамтын ажиллагаа

Нэг

Хүн амын тогтвортой өсөлтийг хангаж, хүн бүрийг эрдэм боловсролтой, хөдөлмөрч, бүтээлч сэтгэлгээтэй, эрүүл амьдралын хэв маягийг хэвшил болгосон, Дорнод аймгийн байгаль, түүх соёл, уламжлааараа бахархсан өв тэгш хүмүүжлээр төлөвшүүлэн, хангалуун сайхан амьдрах эрхийг дээдэлсэн хувь хүний хөгжлийн бодлогыг баримталж, нийгмийн хамгааллын бодлогыг зөвхөн зорилтот бүлэгт чиглүүлнэ.

### Дорнодын гадаадын багасгаа

- 1.1 Дорнод аймгийн сумдын 6 настнуудыг сургуулийн дотуур байранд биш сумын цэцэрлэгт амьдрах, байрлуулах боломжыг бүрдүүлж "Жишиг" аймаг болно.
- 1.2 Бүх шатны боловсролын байгууллагуудын завсарын шатуудын урьдчилан бэлтгэх үйлчилгээг бий болгоно.
- 1.3 Потенциал анализын үнэлгээг дунд сургуулийн 8-р ангиас жил бүр тогтмол хийдэг болгоно.
- 1.4 Дорнод аймагт үйл ажиллагаагаа явуулж байгаа Мэргэжлийн З сургуулийг менежмэнтийн шатлан суралцах сүлжээнд оруулна.
- 1.5 Боловсролын удирдлагын шинэчлэл хийж техникийн ахлах сургууль (лицей) байгуулж сургууль бүрийг "сургуулийн автобус"-тай болгоно.
- 1.6 Хүүхэд бүрийг хөгжүүлж, бүтээлч сэтгэлгээтэй, өөртэй итгэлтэй, орон нутгийнхаа байгаль, түүх, үндэсний хэл соёл, уламжлааараа бахархдаг хүмүүжил олгох "Зөв Хүүхэд" хөтөлбөрийг сэргээн сайжруулж, үргэлжлүүлнэ.
- 1.7 Ардчилал, хүний эрхийн талаарх мэдлэг, ойлголтыг иргэн бүрд төлөвшүүлэх зорилгоор "Зориг"-ын өдөр бий болгоно.
- 1.8 Дорнод их сургуулиа түшиглэн багш нарын мэдлэг, ур чадварыг тухай бүрд нь дээшлүүлж, давтан сургаж хөгжүүлэх зорилгоор "Шинэ багш" хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- 1.9 Дорнод их сургуулийн статусыг нэмэгдүүлж олон улсын чанартай их сургуулийн хөтөлбөрт нийцүүлэн хөгжүүлнэ.


### Чанартай эрхийг мэндийн бийгүйнээ

- 1.10 Тусгай хэрэгцээт /хөгжлийн бэрхшээлтэй/ иргэдтэй ажиллах мэргэжилтэн, дохионы хэлний орчуулагч, мэргэжилтнүүдийг бэлтгэх төлөвлөгөөт арга хэмжээнүүдийг авч, нийгмийн баталгаанд нь дэмжлэг үзүүлнэ.
- 1.11 Сургууль, цэцэрлэг дотуур байр, спорт заал, хүүхдийн хөгжлийн төвийн барилга байгууламжинд тавигдах нэгдсэн стандартыг мөрдүүлнэ. Барилга байгууламж бүхэнд тусгай хэрэгцээт иргэдэд зориулсан зам, шат бүхий хэрэгсэл суулгана.
- 1.12 Мэргэжлийн боловсролын сургуулиадад бүс нутгийн хөдөлмөрийн зах зээлд нийцсэн ур чадвар бүхий мэргэжлийн ангиудыг нээн суралцуулна.
- 1.13 Эрүүл мэндийн 1,2 дугаар шатны тусламж үйлчилгээг иргэдэд улам ойртуулж урьдчилсан сэргийлэх ажлыг жил бүр зохион байгуулна.
- 1.14 Сумдын Эрүүл мэндийн төвүүдийн тоног төхөөрөмжийг үе шаттайгаар шинэчилэнэ.
- 1.15 Дорнод аймгийн Мэргэжлийн З сургуулийг түшиглэн Сувилагчийн сургууль байгуулах.

- 1.16 Төрөөс нийгмийн эрүүл мэндийн талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн төвийг жишиг болгон хөгжүүлнэ.
- 1.17 Бүсийн оншилгоо эмчилгээний төвд түшиглэн эрэгтэйчүүдийн тасаг шинээр байгуулна.
- 1.18 Хэрлэн сумын багийн байршил хүн амын нягтралыг харгалzan өрхийн эмнэлэг нэмж байгуулна.

### Нийгмийн хамгаалал

- 1.19 Ахмадын өдөр өнжүүлэх төвүүдийг бий болгоно.
- 1.20 Нийгмийн халамжийн чиглэлээр сайн дурын ажлыг дэмжих урамшуулах боломжийг бүрдүүлнэ.
- 1.21 Нийгмийн хамгаалалын зорилтот бүлэгт чиглэсэн дэмжлэгийг халамж шаардлагатай өрх иргэдэд хүргэнэ.



### Соёл урлаг, спорт

- 1.22 Аймаг сумдын иргэдэд соёл урлагын үйлчилгээг тэгш хүртээмжтэй хүргэнэ.
- 1.23 Соёл урлагын салбарыг мэргэжлийн хүний нөөцөөр бүрдүүлнэ. 2117144988  
ЖУА9956 9036391
- 1.24 Түүх соёлын үзмэрүүдийн баяжуулалтыг нэмэгдүүлнэ.
- 1.25 Бүх нийтийн боловсролыг дээшлүүлэх үе шаттай арга, соён гэгээрүүлэх хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.26 Бүх ястаны уламжлал соёлын эвент баярын арга хэмжээг улс, аймаг, бүс, олон улсын түвшинд зохион байгуулахад дэмжинэ.
- 1.27 Хоёр хөршийн зэргэлдээ орших аймаг мужуудын хүүхэд залуучуудын дунд спортын арга хэмжээ, хамтарсан бэлтгэл, олон улсын тэмцээн зохион байгуулахыг дэмжинэ.
- 1.28 Олон улсын болон Үндэсний бүх спортын арга хэмжээг мэргэжлийн холбоодтой нь хамтарч зохион байгуулж, дэмжих ажиллана.
- 1.29 "Нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх" хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 1.30 Мэргэжлийн байгууллагуудтайгаа хамтарч хэтийдсэн зөвшөөрлийг багасгаж , ажлын байрыг бий болгох бодлогыг баримтлана.
- 1.31 Хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдалын стандартыг төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудад үе шаттайгаар нэвтүүлнэ.

### Хөгжлийн бүй оргил, наасан хөгжил

- 1.32 Төрөөс баримтлаж буй усны бодлогыг хэрэгжүүлж хиймэл нур, сум бүрд хөв цөөрөм байгуулна.
- 1.33 Ойжуулах, ойг цэвэрлэх, нөхөн сэргээх асуудлыг цогцоор нь шийдвэрлэж, шинэ технологи нэвтрүүлнэ.
- 1.34 Ой, рашаан, булаг хамгаалсан өөрийн хөрөнгөөр нөхөн сэргээсэн иргэн, аж ахуйн нэгжийг урамшуулна.
- 1.35 Баян-Уул, Баяндун, Дашбалбар зэрэг сумдуудад нөхөн ойжуулах хөтөлбөрийг эрчимжүүлж, гол мөрний эх, усны сав, ойн сан бүхий газруудад хууль зөрчин үйл ажиллагаа явуулж буй ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааг бүрэн зогсоон.
- 1.36 Ашигт малтмал олборлолтын явцад хөндөгдөж орхигдсон газар нутагт орон нутгийн иргэдийн оролцоотой нөхөрлөлийн журмаар нөхөн сэргээлт хийх зорилготой үйл ажиллагаан бүрэн хяналт тавьж ажиллана. Хууль зөрчсөн аливаа зөрчил илэрсэн бол даруй зогсоож хуулийн хариуцлага хүлээлгэдэг байдлыг мөрдүүлнэ.
- 1.37 Ойн хортонтой тэмцэх, ойжуулсан талбайд устгал хариутгал хийх замаар ойн чанарыг дээшлүүлэх бодлого баримтална.

### Иргэний хамгаалал

- 1.38 Нийтийн эрүүл мэндийг халдварт өвчин, хүрээлэн буй орчны бохирдоос үүсч болзошгүй тахлын аюулаас урьдчилан сэргийлнэ.
- 1.39 Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг бий болгож зонхилон тохиолдох халдварт өвчний тархалтыг улсын дунджаас бууруулах бодлого баримтална.
- 1.40 Болзошгүй ой, тал, хээрийн болон ахуйн гал түймрийн аюулаас иргэд болон эд хөрөнгө, байгалийн баялагыг хамгаалах зорилгоор онцгой байдлын ангийг Дашбалбар, Чулуунхороот сумдуудад байгуулахад санаачлага гарган хамтран ажиллана.
- 1.41 Малын хулгайн гэмт хэргийг бууруулна.
- 1.42 Иргэний хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлж иргэдэд иргэний хамгааллын мэдлэг олгоно.
- 1.43 Сум суурингуудын гэрэлтүүлгийг нэмэгдүүлж, камерын нэгдсэн хяналтын систем байгуулахад анхаарч ажиллана.
- 1.44 Төр болон хувийн хэвшлийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

117144066  
ЖЮА0056 9036891

### Хоёр

Баялаг бүтээгчдийг төрийн болон орон нутгийн бодлогоор дэмжиж эдийн засгийн хямралын нөлөөллийг багасган, ажлын байрыг нэмэгдүүлэхэд онцгой анхаарч ажиллана. Аж үйлдвэрийн болон эдийн засгийн тэргүүлэх салбаруудаа орон нутгийн төсвийн болон улсын төсвийн бодлогоор дэмжиж, төрөлжүүлнэ. Шинжилэх ухаан, технологийн дэвшлийг үйлдвэрлэл, бизнес, төрийн үйлчилгээний салбарт өргөн нэвтрүүлж инновацийг хөгжүүлнэ.

### Хамгаалыг давах бодлого

- 2.1 Төсвийн зардлыг ач холбогдоор нь эрэмбэлж хямралаас үүдсэн эдийн засгийн хүндрэлд орсон тодорхой салбарт чиглэж ажиллана.
- 2.2 Улсын төсвийн болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх бүтээн байгуулалт болон бараа үйлчилгээний худалдан авалтыг орон нутгийн тогтвортой үйл ажиллагаа явуулж байгаа, ажлын байр бий болгодог аж ахуй нэгжээр гүйцэтгүүлэх бодлого баримтална.
- 2.3 Газрын тосны олборлолт явуулж буй компани болон ашигт малтмал олборлох боловсруулах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай төслүүдтэй хамтран гурван талд хэлцэл байгуулах замаар хөнгөлөлттэй үнээр орон сууц барих хөтөлбөр хэрэгжүүлнэ.

### Ослитийн бодлого

- 2.4 Үйлдвэржилт
  - 2.4.1 Хоёр хөрштэйгээ жижиг дунд үйлдвэрлэлийн чиглэлээр хамтран ажиллаж экспортыг дэмжих бодлого хэрэгжүүлнэ.
  - 2.4.2 Мал аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрийг орон нутгийн бодлогоор дэмжиж ажиллана.
  - 2.4.3 Барилгын материалын үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, хуулийн хүрээнд таатай нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллана.
  - 2.4.4 Хөнгөн үйлдвэрийн кластрын системийг нэвтрүүлж Дорнодын брэнд бүтээгдэхүүнийг улс, олон улсын зах зээлд борлуулахад дэмжлэг үзүүлнэ.
  - 2.4.5 Уул уурхайн салбарын олборлосон түүхий эдийг баяжуулж экспортлох бодлого хэрэгжүүлж баяжуулах үйлдвэрүүдийг дэмжинэ.
  - 2.4.6 Нуурсний ордыг түшиглэн өрхийн, аж үйлдвэрийн хэрэгцээнд нүүрс шигших ялгах бага оврын үйлдвэр байгуулахыг дэмжинэ.

- 2.5 Бизнес эрхлэлт
- 2.5.1 Байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, төр хувийн хэвшил, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг сайжруулна.
- 2.5.2 Олон улсын гаалийн баталгаат агуулахын талаархи бизнесийг дэмжинэ.
- 2.5.3 Онон гол, Халхгол-Буйр нуур, түшиглэн хил орчмын аялал жуулчлалыг хөгжүүлнэ.
- 2.5.4 Байгалийн дурсгалт газрыг түшиглэн Эко системд нөлөөлөхгүй аялал жуулчлалын бааз байгуулахыг дэмжинэ.
- 2.6 Дэд бүтэц, хот төлөвлөлт, бүтээн байгуулалт
- 2.6.1 Дорнод НАА ОНӨГ ус цэвэршүүлэх төхөөрөмжид шинэчэл хийнэ.
- 2.6.2 ДЦС-ын 50 МВт-ын өргөтгөлийг ажлыг гүйцэтгүүлж дуусган Сүхбаатар, Хэнтий аймгийн хэрэглэгчдийг хангана.
- 2.6.3 ДБЭХС-ийг Төвийн эрчим хүчний системтэй 220 кВ-ын шугамаар холбож, МУ-ын ЭХ-ний системтэй зэрэгцээ ажиллуулж цахилгаан хангамжийг сайжруулна.
- 2.6.4 ОС-ны босоо шугамуудыг шинэчлэнэ.
- 2.6.5 Хорооллын дундах замыг хатуу хучилттай болгох ажлыг үргэлжлүүлнэ.
- 2.6.6 СМУ хороололыг дахин төлөвлөлтөнд оруулж хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, шинэ орон сууцны хороолол байгуулна.
- 2.6.7 Орон сууцны байруудын засвар үйлчилгээ хийх, тохижилтын “Орон сууц хөгжлийн сан”-г бий болгоно.
- 2.6.8 Монгол Өрх 2020, Алсын хараа 2050 хөгжлийн бодлогын хүрээнд зүүн бусийн тулгуур төвийн төлөвлөлтөнд нийцүүлэн Хэрлэн сум, Чойбалсан хотын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.
- 2.6.9 Хэрлэн голын үерийн усыг нөөцлөх санг байгуулж, газар тариалан, загас үржүүлгийн аж ахуйд ашиглах, Хэрлэн голын усны тохируулгыг хийх алба байгуулана.
- 2.6.10 Хилийн боомтуудын дэд бүтцийг хөгжүүлнэ.
- 2.6.11 Чойбалсан хотыг Ногоон бус хот болгох төсөл хэрэгжүүлнэ
- 2.6.12 Чойбалсан хотын цэвэр, Бохир усны болон дулааны шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх/ Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр/ шийднэ.
- 2.6.13 Хэрлэн голын бус дагуу ил спорт талбай бүхий тохижилтыг нэмэгдүүлнэ.
- 2.6.14 Чойбалсан хотын ногоон байгууламжийг нэмэгдүүлнэ. Иргэдийн болон аж ахуй нэгжийн оролцоотой тохижилтын хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.
- 2.6.15 Аюулгүй амар тайван орчныг бүрдүүлэхэд Чойбалсан хотыг бүрэн хэмжээнд хяналтын камерын системтэй болгож нэгдсэн удирдлагатай болгоно.
- 2.6.16 Хүүхэд, ахмадын чөлөөт цагаа өнгөрүүлэх төвүүдийг байгуулж иргэддээ зэлтэй орчныг бүрдүүлнэ.
- 2.6.17 Авто зам болон явган зорчигч, дугуйт зорчигчын замын ухаалаг төлөвлөлтийг нэвтрүүлж замын нэгдсэн сүлжээг бүрэн шинэчлэнэ.
- 2.6.18 Цэцэрлэгт гудамжийн тоог нэмэгдүүлж гэр хорооллын бусэд нийтийн амралт зугаалгын цэцэрлэгт хүрээлэн байгуулна.
- 2.6.19 Чойбалсан хотын гэр хорооллын хөрсний бохирдлыг бууруулахад онцгой анхаарч ажиллана. “Жорлонгоо шинэчлэе” хөтөлбөрийг сурталчилан таниулж, иргэдийн санаачлагатай уялдуулж ажиллана. Нүхэн жорлонгийн тоог бууруулна.
- 2.6.20 Залуучуудын чөлөөт цагаа өнгөрүүлэх төвүүдийг улсын төсөв, орон нутгийн төсөв, хувийн хөрөнгө оруулалтанд тулгуурлан байгуулах ажлыг дэмжинэ.
- 2.6.21 Чийрэгжүүлэх төвүүдийг дэмжиж, хуулиар олгосон боломжид тулгуурлан хөнгөлөлт үзүүлж ажиллана.
- 2.6.22 Усан бассейн байгуулах хөрөнгө оруулалтын ажлыг дэмжинэ.
- 2.6.23 Чөлөөт цагаа өнгөрүүлэх авто спортын зам, адал явдалт явган аялалын бус байгуулах ажлыг дэмжинэ.

- 2.6.24 Хувийн хөрөнгө оруулалтыг дэмжиж соёл урлагын төв байгуулах ажлыг хэрэгжүүлнэ. Кино театр, спорт тоглоомын төвүүдийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ.
- 2.7 Шинжилэх ухаан, технологи, инноваци
- 2.7.1 ЭХ-ний шөнийн тарипын хөнгөлөлтийг ашиглан Цахилгаан автобус нийтийн тээвэрт ашиглах, цахилгаан машин цэнэглэх цэгүүд байгуулна.
- 2.7.2 Сэргээгдэх эрчим хүчний нар, салхины цахилгаан станцуудыг байгуулах төсөлүүдийг дэмжиж ажиллана.
- 2.7.3 Хэрлэн голд ус хуримтлуурын жижиг усан цахилгаан станцыг байгуулах төслийг дэмжиж ажиллана.
- 2.8 Хөдөө аж ахуй, газар тариалан
- 2.8.1 Чойбалсан хот болон сум суурин орчмын үржил шимт газруудад хүнсний ногоо тариалах талбайг иргэдэд түрээсээр эзэмшүүлж хөнглөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжиж ажлын байр бий болгоно.
- 2.8.2 Малчин өрхүүдийн санхүүгийн хуримтлалыг нэмэгдүүлэх зорилгоор санхүү, бүртгэл хөтлөлийн чиглэлээр мэдлэгжүүлэх бодлого барьж ажиллана. "Чинээлгэ малчин" үндэсний хөтөлбөрийг орон нутагт эрчимтэй хэрэгжүүлнэ.
- 2.8.3 Мал, малын гаралтай бүтээгдэхүүний экспортод гаргах боломжийг өргөтгэх, мал эмнэлгийн эрүүл ахуйн зохистой орчинг боловсронгуй болгож, олон улсын жишигт нийцсэн үндэсний мал, амьтны эмнэлгийн тогтолцоонд шилжих.
- 2.8.4 Дорнод аймгийн мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг нэмэгдүүлж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог нэмэгдүүлнэ. Гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулан, түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, хадгалалт, тээвэрлэлтийн сүлжээг аймаг, сумын түвшинд хөгжүүлэх.
- 2.8.5 Хөрсний үржил шимиийг нэмэгдүүлэх, газрын доройтлыг бууруулах, хөрс тордох агротехникийн болон усалгааны хэмнэлттэй, үр ашигтай дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үр тариа, төмс, хүнсний ногооны дотоодын хэрэгцээг хангах хүрээнд газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ.
- 2.8.6 Алслагдсан бэлчээрийг ашиглах зорилгоор гүний инженерийн хийцтэй худгийг жилд 20-оос доошгүй гаргана.
- 2.8.7 Отор дундын бүсийг зүй зохистой ашиглана.
- 2.8.8 Бэлчээрийн зохистой менежментийг нэвтрүүлж хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлнэ.
- 2.8.9 Ямаан сүргийн зохистой харьцааг шинжлэх ухааны үндэстэй тогтооно.
- 2.8.10 Аймгийн мал сүрэг дэх тэмээн тоо толгойг нэмэгдүүлэх бодлого хэрэгжүүлнэ.
- 2.8.11 Малын эрүүл мэнд, үржлийн асуудлаар Бүс нутгийн хэмжээнд үйлчилгээ үзүүлэхүйц хамтарсан аж ахуйнуудыг дэмжинэ
- 2.8.12 Дорнод аймгийг Монгол улсын хонины аж ахуйн стандартын шаардлага хангасан хөгжлийн төв болгон хөгжүүлнэ.
- 2.8.13 Цөм сүргийн бүтцүүдийг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтанд оруулна.
- 2.8.14 Мал аж ахуйн судалгаа, шинжилгээ, инноваци, технологийн олон улсын болон бүсийн төвүүдийг байгуулна
- 2.8.15 Мал аж ахуй, газар тариалан хосолсон өрх дундын аж ахуйнуудыг байгуулна
- 2.8.16 Мал сүргийн бүтцийн зохист харилцааг урамшуулан дэмжинэ. /Татвар болон бусад хэлбэрээр/
- 2.8.17 Малын бүртгэлийн олон улсын системийг нэвтрүүлнэ.
- 2.8.18 Хөрсний элэгдлийг бууруулах, эрүүл, аюулгүй органик хүнсний үйлдвэрлэлийг дэмжинэ.

2.8.19 Хүчин чадал өндөртэй техник, тоног төхөөрмжийн дундын үйлчилгээ үзүүлэх аж ахуйнуудыг байгуулна.

2.8.20 Газар тариалан эрхэлдэг аж ахуйнуудыг хөрс хамгаалах ойн зурvas байгуулах, байгальд ээлтэй орчин үеийн усалгаат тариалан \дуслын систем\ эрхлэхэд дэмжлэг үзүүлнэ.

2.8.21 Мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагаас баталгаажуулсан худалдаа, хорио цээрийн шаардлагад нийцсэн мал, амьтны өвчингүй статустай нутгийг бий болгоно.

2.8.22 Хэрлэн голын гадаргын усыг Чойбалсан хотын өрхийн тариалалтын хэрэгцээнд ашиглах ажлыг эхлүүлнэ.

## Гурав

Хот, хөдөөгийн хөгжлийн суурь өгөгдлийн ялгааг арилгахад чиглэсэн төрийн бодлого хэрэгжүүлж эдийн засгийн микро бүсүүдийг бий болгоно. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон бэлчээрийн малын удмын сан, тэсвэрт чанарыг хадгалж, ашиг шимийг нь нэмэгдүүлэх, бэлчээрийн даацад нийцсэн мал сүргийн тоо, төрлийн зохистой харьцааг бүрдүүлэх, бэлчээрийн газрын доройтлыг бууруулж, нөхөн сэргээх, мал, амьтны өвчиний тандалт, хяналт, үйлчилгээний технологид олон улсын стандартыг нэвтрүүлэн, олон улсын зах зээлд өрсөлдөх чадвартай мал аж ахуйн салбарыг хөгжүүлнэ. Чойбалсан хотыг бус нутгийн хөгжсөн хотуудын хэмжээнд хүрч хөгжих хөгжлийн бодлого хэрэгжүүлнэ.

## Аймаг, сумын хөгжлийн тэнцүүр

- 3.1 Зүүн бүсийн тулгуур төвийн үйл ажиллагааг эрчимжүүлнэ.
- 3.2 Хэрлэн сумын байрлалд ойр сумдын эдийн засгийн харилцааг бодлогоор дэмжиж харилцан хүртээмжтэй, хэлбэрээр төрөлжүүлж хөгжүүлнэ.
- 3.3 Баян-Уул болон Баяндун сумуудыг өрсөлдөж биш хамтран хөгжих зарчмаар эдийн засгийн хөгжлийн төрөлжилт бий болгоно.
- 3.4 Дашбалбар болон Гурванзагал, Чулуунхороот сумдыг хэвтээ тэнхлэгээр Эрээнцавын худалдааны интеграцид идэвхитэй оролцох боломжийг бүрдүүлнэ.
- 3.5 Иргэдийн оролцоотой болон концесс , төсвийн дэмжлэгтэйгээр “Шинэ сум” төсөл хэрэгжүүлнэ.
- 3.6 Аймгийн бүх сумдыг сум тус бүрд нь нэгдсэн халаалтын системд холбоно.
- 3.7 Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй Уул уурхай, газрын тосны компаниудын үйл ажиллагааны тендерийг нээлттэй явуулж, орон нутгийн компаниудыг оролцох боломжийг нээнэ.
- 3.8 Сумдын төрийн үйлчилгээний байгууллагуудад ХАБЭА-н стандартыг нэвтрүүлнэ.
- 3.9 Хөдөөгийн сумдын төвийн ундны цэвэр усны асуудлыг бүрэн шийдвэрлэнэ.
- 3.10 Газрын тосны борлуулалтаас орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгөөс тухайн сум орон нутгийн дэд бүтцийг сайжруулахад анхаарч ажиллана.

## Шинэ засаглал

Төрийн албыг чадвар, туршлагатай, зэрэг хандлага бүхий цомхон багаар ажиллах шинэ хэлбэрт шилжүүлж, санхүү төсвийн нээлттэй, ил тод байдлыг бий болгоно. Орон нутгийн засаг захиргаа болон иргэний хоорондын хамтын ажиллагааг сайжруулж иргэдийн санал, санаачлагыг төрийн ажилд тусгаж хэрэгжүүлдэг болно. Зүүн хойд ази, Дорнод сибирын худалдаа, аялал жуулчлал, тээвэр, эдийн засгийн интеграцид санаачлагатай, идэвхитэй оролцох чадамж бүхий хүний нөөцийг нэмэгдүүлж засаглалын чадамжийг дээшлүүлнэ.

Санаачлагатай, дэмжих, шинэ хандлагыг төрийн үйлчилгээний албандаа эрс нэмэгдүүлнэ.

- 3.11 Нээлттэй, иргэний хяналт
- 3.11.1 Төсвийн зарцуулалт, хөрөнгө оруулалт, худалдан авалт, санхүүгийн тайланг иргэдэд ил тод болгоно.
- 3.11.2 Аливаа лиценз, зөвшөөрөл олгох үйл явцыг хуульд нийцүүлэн шуурхай, хуртээмжтэй болгож бүрэн шинэчлэн зохион байгуулна.
- 3.11.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалт, орон нутгийн төсвийн хөрөнгийн зарцуулалтыг иргэдэд нээлттэй болгож "Шилэн данс"-ны хуулийг мөрдүүлэн ажиллана.
- 3.11.4 Татвар төлөгчдийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулж байгаа эсэхэд хяналт тавин аймгийн төсвийн орлого, зарлагын төсөл, тайланг сар бүр гаргаж "Иргэний танхим"-аар нээлттэй хэлэлцүүлж, санал дүгнэлтийг тусган ажиллана.
- 3.11.5 Иргэдийн төлөөлөгчдийн хурлын үйл ажиллагааг бүх иргэдэд нээлттэй, ил тод байлгаж, хэвлэл мэдээллийн хэрэгслэлээр шууд дамжуулан, гарсан шийдвэрийг тухай бүрд нь олон нийтийн сүлжээнд байршуулж, цахим засаглалыг хэрэгжүүлнэ.
- 3.11.6 Нийгмийн амьдралын үйл ажиллагаанд нөлөөлөх аливаа томоохон шийдвэрийг иргэдээсээ асуудаг, иргэдээрээ хянуулдаг байдлыг нэвтрүүлж ажиллана.
- 3.11.7 Аймгийн засаг дарга болон Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дэргэд туршлагатай, салбар салбарын төлөөллийг оролцуулсан "Бодлогын зөвлөх зөвлөл" байгуулан ажиллуулна.
- 3.11.8
- 3.12 Хариуцлагатай, чадварлаг
- 3.12.1 Төрийн алба болон үйлчилгээний албанад ажиллагсдын ёс зүйн хэм хэмжээг нэмэгдүүлж, хяналттай хариуцлагатай засаглалыг төлөвшүүлнэ.
- 3.12.2 Төрийн болон төрийн үйлчилгээний албанад ажиллагсдын ур чадварыг бодитоор дээшлүүлэхэд онцгой анхаарна. Давтан сургах, дадлагажуулах ажлыг тасралтгүй сургалцах хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ.
- 3.12.3 Төрийн үйлчилгээний "Нэг цонх үйлчилгээ" хөтөлбөрийг эрчимтэй хэрэгжүүлж, сум бүрийг цахимжуулна.
- 3.12.4 Аймаг сумын хэмжээнд нийт хурал, уулзалтыг 50 хувь цахим хэлбэрээр хийх бодлого барьж ажиллана.
- 3.12.5 Төрийн жинхэнэ албан хаагчдын шалгалтын үйл явцыг өндөр хяналттай болгох, түүвэр хяналтын шалгалтыг тогтмолжуулах.
- 3.12.6 Төрийн албаны цаг ашиглалт, бүтээмжийг нэмэгдүүлэхэд тодорхой хөтөлбөр хэрэгжүүлж ажиллана.
- 3.12.7 Хуулийг бүх шатанд чанд мөрдүүлж, авилгаас ангид, иргэдийн оролцоог хангасан, мэргэшсэн, тогтвортой орон нутгийн засаглалыг хэрэгжүүлнэ.
- 3.12.8 Орон нутгийн бизнес, хөгжлийн харьцангуй давуу талд тулгуурлан шинээр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх шинэ санаа, шилдэг санаачлагыг бодлогоор дэмжиж ажиллана.
- 3.12.9 Өндөр технологийн чиглэлээр ажиллах боловсон хүчнийг анхнаас нь дэмжиж хөгжүүлнэ.
- 3.12.10 Хэрлэн гол дагасан салхины урсгал дагуу цахилгаан хэрэглээ ихтэй Ай ти сервер роом байгуулж мэдээллийн технологийн старт апп-уудыг богино хугацааны үр дүн харахгүйгээр дэмжинэ.

### Баялагтаа зүн

- 3.13 Уул уурхайн баялагаас орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана.

## Дөрөв

### 4.1 Гадаад хамтын ажиллагаа

- 4.1.1 “Орос, Хятадын нэг бүс-нэг зам” төсөлд идэвхитэй, санаачлагатай оролцох чиглэлээр бие даасан санаачлага хөтөлбөр дэвшүүлж гурван талт хамтын ажиллагаа, олон улсын хөгжлийн интеграцид нэгдэж ажиллана.
- 4.1.2 Аймгийн хөгжлийн бодлогын чиглэлээр ажиллаж байгаа бүрэлдэхүүнийг 100 хувь гадаад хэлтэй, чадварлаг боловсон хүчинээр бүрдүүлж ажиллана.
- 4.1.3 Чойбалсан хотыг Зүүн хойд Азийн аялал жуулчлал, бизнес худалдааны чөлөөт бүс болгоно.

2117144006  
ЖЮА0056 9030891